

## АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төвийн мэргэжилтнүүд үнэлгээ хийв

АНУ-ын Атланта хот дахь Өвчний Хяналт, Сэргийлэлтийг Төв (ӨХТ)-ийн Томуугийн салбарын, улс хоорондын хөтөлбөрийн Монгол улсыг хариуцсан ажилтан Тереза Турски тэргүүтэй мэргэжилтнүүд манай улсын томуугийн лабораторийн ба эпидемиологийн тандалтын үйл ажиллагаанд 2010 оны 6 дугаар сарын 21-нээс 25-нд үнэлгээ хийж, зөвлөмж гаргалаа.

АНУ-ын Род Айланд муж улсын Нийгмийн эрүүл мэндийн лабораторийн эрхлэгч Роберт Айрланд, АНУ-ын ӨХТ-ийн Томуугийн лавлагаа лабораторийн мэргэжилтэн, доктор Бо Шү нар ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторит ажиллаж АНУ-ын ӨХТ-өөс боловсруулсан лабораторийн үнэлгээний 10 бүлэг асуумжийн дагуу ярилцлага хийж, ТҮТ-ийн

28 мэргэжилтэн оролцож үнэлгээг 2008 онд боловсруулсан асуумжийн дагуу 2008 онд хийсэн үнэлгээний дүнтэй харьцуулан хийв (Хүснэгт 1). Томуугийн цар тахлын бэлэн байдлын одоогийн үнэлгээний нэгдсэн дүн 1,77 оноотой буюу дундаж түвшинд байна гэж үзлээ.

Хүснэгт 1

°	Чадавх / үзүүлэлт	Оноо			
		заалт тус бүрээр		дундаж	
1	Үндэсний төлөвлөгөө	2008	2010	2008	2010
1.1	Томуугийн цартахлын бэлэн байдлыг хангах үндэсний төлөвлөгөөтэй эсэх	2	2	1.60	1,90
1.2	Төлөвлөгөөг тарааж, сургалт зохион байгуулсан байдал	2	2		
1.3	Үзүүлэх сургууль, дасгал	2	2		
1.4	Үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохицуулалт, нөөц	1	1		
	Үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөц	1	2		
2	<i>Томуугийн цартахлын бэлэн байдлыг хангах чиглэлээр хийгдэж буй судалгаа шинжилгээний ажил, тэдгээрийн хэрэглээ</i>				
2.1	Хүн, мал амьтны эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаа	1	2	1.00	2.00
2.2	Судалгаа шинжилгээний тэргүүлэх чиглэлүүд	1	2		
2.3	Судалгаа шинжилгээг гүйцэтгэхэд гадаад орчноос үзүүлэх дэмжлэг	1	2		
2.4	Мэдээ баримтыг ашиглан томуугийн цартахлын бэлэн байдлыг хангах чиглэлээр шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах	1	2		
3	<i>Харилцаа холбоо</i>				
3.1	Харилцаа холбоог хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал	2	2	2.25	2.25

3.2	Мейсэж боловсруулалт	3	3		
3.3	Түгээлт / тараалт	2	2		
3.4	Хүн хүчин	2	2		
4	<i>Эпидемиологийн чадавх</i>				
4.1	Өнөөгийн нөхцөл байдал	0	0	1.25	1.5
4.2	Эпидемиологичид, талбарын эпидемиологичид	2	2		
4.3	Нийгмийн эрүүл мэндийн эпидемиологичдын чанар	1	2		
4.4	Сургалт	2	2		
5	<i>Лабораторийн чадавх</i>				
5.1	Томуугийн лабораторийн үндэсний сүлжээ	1	2	1.75	2.0
5.2	Биоаюулгүй ажиллагааны түвшин, сорьцыг байнга шинжлэх үйл явц	2	2		
5.3	Аргачлал	2	2		
5.4	ДЭМБ-ын сүлжээнд оролцдог байдал	2	2		
6	<i>Томуугийн байнгын тандалт</i>				
6.1	Вирусологийн болон эпидемиологийн тандалтын уялдаа холбоо	2	3	2.50	3.0
6.2	Мэдээ баримтыг нийтлүүлэх байдал	3	3		
6.3	Цаг хугацаандаа мэдээлдэг байдал	2	3		
6.4	Тохиолдлын тодорхойлолтууд	3	3		
7	<i>Амьсгалын өвчнийг тандах үндэсний тогтолцоо ба мэдээлэлт</i>				
7.1	Өвчний талаарх шаардлагатай мэдээллийг түгээх байдал	2	3	1.25	1.75
7.2	Ам дамжсан яриа, цуурхлыг мэдээлэх үйл явц	0	1		
7.3	Салбар хоорондын харилцан мэдээлэлт	1	1		
7.4	Цаг хугацаандаа мэдээлсэн байдал	2	2		
8	<i>Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ</i>				
8.1	Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ хариуцсан хүн хүчний нөөц	1	2	1.00	1.75
8.2	Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээнд зориулсан эд материалын нөөц	0	1		
8.3	Дасгал сургуулилт болон хариу арга хэмжээ	1	2		
8.4	Багийг идэвхжүүлэх	2	2		
9	<i>Дэгдэлтийг хязгаарлан барих нөөц</i>				
9.1	Вирусийн эсрэг үйлдэлтэй эм бэлдмэл	0	0	0.25	0.75
9.2	Хадгалах багтаамж	1	1		
9.3	Дасгал сургуулилт	0	1		
9.4	Материалыг түгээх / тараах	0	1		
10	<i>Томуугийн тархалтаас сэргийлэх олон нийтэд суурьласан арга хэмжээ</i>				
10.1	Нийгмийн хорио	2	2	1.50	2.0
10.2	Зайлшгүй шаардлагатай дэд бүтэц	0	1		
10.3	Сайн дурын тусгаарлалт, хөл хорио	1	2		
10.4	Өөрийн төлөвлөгөөтэй дүүргийн эзлэх хувь	3	3		
11	<i>Халдвар хамгаалал</i>				
11.1	Эрүүл мэндийн тогтолцооны түвшин бүр дэх халдвар хамгааллын стандарт дэглэм	2	2	0.75	1.5
11.2	Хүний нөөц	2	2		
11.3	Эд материалын нөөц	1	0		
11.4	Халдвар хамгааллын үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд мөрдөх	2	2		
12	<i>Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал</i>				
12.1	Хүний нөөц	0	1	0.5	0.88
12.2	Эд материала, тоног төхөөрөмжийн нөөц	0	0.5		
12.3	Эмнэлзүйн менежмент	2	2		
12.4	Оршуулга	0	0		
	ДҮН			1.38	1.77

**Томуугийн цар тахлын бэлэн байдлын үнэлгээний**

**2008 болон 2010 оны харьцуулсан дүн**

ЭМЯ-ны мэргэжилтэн Д.Нарангэрэл, ХӨСҮТ-ийн захирал Д.Нямхүү, дэд захирал Г.Сүрэнханд нар АНУ-ын ӨХСТ-ийн үнэлгээ хийсэн багийн болон манай мэргэжилтнүүд оролцсон үнэлгээний урьдчилсан дүнг танилцуулах уулзалт ярилцлагад 2010 оны 6 дугаар сарын 25-нд оролцлоо. Манай улсын томуугийн лабораторийн ба эпидемиологийн тандалтын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх ажил амжилттай болж өнгөрлөө.

**Р.Туул  
Монгол-АНУ-ын хамтарсан**

“Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх” төслийн менежер

**Орхон, Дархан-Уул аймагт вирус судлалын салбар лаборатори байгуулагдлаа**

2010 оны 2 сарын 8-13-д ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторийн эмч, анагаах ухааны магистр Ц.Наранзул вирус судлалын салбар лабораторийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор Орхон, Дархан-Уул аймгуудын Нэгдсэн эмнэлэгт ажиллалаа.

Дэлхийн банкны “Шувууны томуу, хүний томуугийн цартахалтай тэмцэх чадавхийг сайжруулах”, АНУ-ын ӨХСТ-ийн “Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх” төслийн санхүүжилтээр нийлүүлэгдэж буй багаж төхөөрөмжийг суурилуулж, лабораторийн хэрэгсэл зарим урвалж бодисуудыг хүлээлгэн өгөв. Салбар лабораториудад томуугийн вирусийн өвөрмөц ген илрүүлэх Бодит Хугацааны Полимеразын Гинжин Урвал(бх-ПГУ)ын машин суурилагдаж, лабораторийн шинжилгээ эхэллээ.